



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 18 өдөр

Дугаар А/394

Номгон

Аймгийн Засаг даргын 2019 оны “Газар”
эзэмшүүлэх тухай” А/12 дугаар захирамжийг
хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3, Газрын тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Иргэн С.Думаагийн газар эзэмших эрхийг сэргээсэн аймгийн Засаг даргын 2019 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн “Газар эзэмшүүлэх тухай” А/12 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

2.Хүчингүй болсон газрын мэдээллийг улсын бүртгэлд тусгуулж, газар эзэмшигчид мэдэгдэхийг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Т.Алтангэрэл)-т үүрэг болгосугай.

3.Энэ захирамж гарсантай холбогдуулан газрын гэрээ, гэрчилгээ, кадастрын зураг зэрэг бусад бичиг баримтыг хураалгахыг иргэн С.Думаад үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай.

5.Энэхүү шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд 30 хоногийн дотор дээд шатны байгууллагад гомдол гаргах эрхтэйг дурдсугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

621010989